

## **МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДЭРГЭДЭХ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү дүрмээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Иргэний нийгмийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын эрх зүйн байдлын талаарх Зарчим (Парисын зарчим) болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, оролцоог хангах, ил тод, хараат бус байх, санаачилгатай ажиллах нь Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн зарчим байна.

1.4. Зөвлөл Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (цаашид “Комисс” гэх)-ын үйл ажиллагаанд иргэний нийгмийн олон талт оролцоог хангаж Комиссын үйл ажиллагаанд дараах байдлаар дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байна. Үүнд:

1.4.1. Хүний эрхийн Үндэсний Комиссын тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал өгөх;

1.4.2. Хүний эрхийн асуудлаар шинжээчийн дүгнэлт гаргах;

1.4.3. Хүний эрхийн аливаа зөрчил, эрсдэлийн талаарх мэдээллээр хангах, тэдгээрээс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах;

1.4.4. Комиссын зорилго, чиг үүрэг, гомдол шийдвэрлэх талаарх ойлголт, мэдлэгийг түгээхэд дэмжлэг үзүүлэх;

1.4.5. Сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх болон нөлөөллийн үйл ажиллагаанд оролцох;

1.4.6. Комисст гомдол гаргах асуудлаар хохирогчид дэмжлэг үзүүлэх;

1.4.7. Комиссын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай мэдээллээр хангах;

1.4.8. Хууль тогтоомж, хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахтай холбоотой баримт бичгүүд, тэдгээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, тэдгээрийг сайжруулах санал гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

1.5. Зөвлөл нь дарга, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй байна.

1.6. Зөвлөл нь хүний эрхийн асуудал эрхэлсэн ашгийн төлөө бус хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаачийг оролцуулсан хүний эрхийн олон талын салбар чиглэлийг хариуцсан дараах төлөөлөл бүхий гишүүдтэй байна. Үүнд:

- 1.6.1. иргэний болон улс төрийн эрхээр мэргэшсэн 5 гишүүн;
- 1.6.2. эдийн засаг, нийгэм, соёлын эрхээр мэргэшсэн 5 гишүүн;
- 1.6.3. зорилтот дараах бүлгийн эрхээр мэргэшсэн 8 гишүүн. Үүнд:
  - 1.6.3.1. хүүхдийн эрх;
  - 1.6.3.2. эмэгтэйчүүдийн эрх;
  - 1.6.3.3. эрэгтэйчүүдийн эрх;
  - 1.6.3.4. ахмад настны эрх;
  - 1.6.3.5. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх;
  - 1.6.3.6. үндэстний цөөнхийн эрх;
  - 1.6.3.7. хэлний цөөнхийн эрх;
  - 1.6.3.8. бэлгийн цөөнхийн эрх.

### **Хоёр. Хүний эрхийн Үндэсний Комисс ба Иргэний нийгмийн зөвлөлийн хоорондын үйл ажиллагаа**

2.1. Комиссоос Зөвлөлийн нарийн бичгийн даргаар дамжуулан шаардлагатай үйл ажиллагааны талаар Зөвлөлд буюу түүний гишүүнд тухай бүр урьдчилан мэдэгдэнэ.

2.2. Зөвлөлөөс өөрийн санаачилгаар Комисст дэмжлэг үзүүлэх тодорхой саналаа Зөвлөл хариуцсан Комиссын гишүүн буюу Зөвлөлийн дарга, эсхүл Зөвлөлийн нарийн бичгийн даргаар дамжуулан Комисст мэдэгдэж болно.

2.3. Зөвлөл, түүний гишүүд нь Комисст энэ дүрмийн 1.4-т заасан дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг дараах байдлаар зохион явуулна:

- 2.3.1. Комиссын хуралдаанд Зөвлөлийн даргын санаачилга, Комиссын даргын зөвшөөрлөөр оролцох;
- 2.3.2. Комиссын хуралдаанд амаар танилцуулга хийх;
- 2.3.3. Зөвлөлийн гишүүд харъяалах чиглэлээрээ 45 хоног тутам мэдээлэл бэлтгэж ирүүлэх, Комиссын хуралдаанд танилцуулга хийх;
- 2.3.4. Комиссын захиалгаар тухайлсан асуудлаар судалгаа хийх, баримт бичиг бэлтгэх;
- 2.3.6. Комиссоос зохион байгуулах хурал, хяналт шалгалт, бусад үйл ажиллагаанд оролцох;
- 2.3.7. Комиссын хуралдаанд хүний эрхийн асуудлаар шинжээчийн дүгнэлт гаргаж танилцуулах;
- 2.3.8. Хүний эрхийн зөрчлийг зогсоох, сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд Зөвлөлөөс Комиссын гишүүнийг оролцуулах хүсэлт гаргах.

2.4. Зөвлөлийг төлөөлж Комиссын хуралдаанд оролцох гишүүн нь Комиссын тухайн хуралдаанд хэлэлцэж буй асуудлаар мэргэшсэн, туршлагатай гишүүн байвал зохино.

2.5. Зөвлөлийн гишүүнийг Комиссын хуралдаанд оролцуулах ажлыг Тамгын газраас зохион байгуулна.

2.6. Комиссын захиалгаар хүний эрх, эрх чөлөөнд хамаарах тухайлсан асуудлаар мэргэшсэн Зөвлөлийн гишүүн буюу гишүүд хамтран судалгаа хийх, баримт бичиг бэлтгэх үүргийг хэрэгжүүлэх тохиолдолд санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

2.7. Зөвлөлийн гишүүн Комиссоос зохион байгуулах хяналт шалгалтын ажилд өөрийн мэргэшсэн чиглэлийн дагуу Комиссын даргын баталсан удирдамжийн хүрээнд оролцож болно.

2.8. Комиссоос зохион байгуулах хурал, уулзалтад илтгэл хэлэлцүүлэх эсэх асуудлыг Зөвлөлийн гишүүдийн саналын үндсэн дээр хурлын сэдэв, хөтөлбөр, оролцогчийн тоо зэрэг нөхцөл байдлыг харгалзаж Комиссын хуралдаанаар шийдвэрлэнэ.

2.9. Энэ дүрмийн 2.3-т заасан үйл ажиллагааны хүрээнд Зөвлөл, түүний гишүүнээс гаргасан дүгнэлт, саналыг Комисс судлан үзэж, шаардлагатай бол холбогдох баримт бичиг, шийдвэрт тусгах эсэхийг Комиссын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### **Гурав. Зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх**

3.1. Зөвлөлийн дарга нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, нарийн бичгийн дарга нь Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын ажилтан байх бөгөөд тэдгээрийг Комиссын хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Комиссын дарга томилно.

3.2. Зөвлөлийн гишүүн нь энэ дүрмийн 1.6-д заасан хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудыг төлөөлөх дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн байна. Үүнд:

3.2.1. хүний эрхийн асуудал эрхэлсэн ашгийн төлөө бус хуулийн этгээд, эсхүл эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн багш, судлаач;

3.2.2. хүний эрхийн чиглэлээр сүүлийн гурван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан, эсхүл эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлсэн байх;

3.2.3. улс төрийн намын харьяалалгүй байх, эсхүл түдгэлзсэн тухай шийдвэр гарсан байх.

3.3. Зөвлөлд энэ дүрмийн 1.6-д заасан байгууллагыг төлөөлөх гишүүнийг төрийн бус байгууллагуудаас дээрх шалгуурын дагуу нэр дэвшүүлэн сонгон шалгаруулж Комисст ирүүлнэ. Сонгогдсон нэр дэвшигчийг Хүний эрхийн Үндэсний Комиссын хуралдаанаар хэлэлцэн Комиссын даргын тушаалаар томилно.

3.4. Зөвлөлийн гишүүдийг томилохдоо жендэрийн тэнцвэртэй байдлыг харгалзана.

3.5. Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд дараагийн гишүүн томилогдсоноор дуусгавар болно.

3.6. Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 3 сарын өмнө дараагийн нэр дэвшигчдийг тодруулсан байна.

3.7. Зөвлөлийн гишүүнийг нөхөн томилоход энэхүү дүрмийн 3.2-т заасныг баримтална.

3.8. Зөвлөлийн гишүүнийг дараах үндэслэлээр Комиссын даргын тушаалаар чөлөөлнө. Үүнд:

3.8.1. Эрхэлж буй ажил, албан тушаал өөрчлөгдсөний улмаас Зөвлөлийн гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;

3.8.2. Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар Зөвлөлийн гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсноор өөрөө хүсэлт гаргасан;

3.8.3. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж, шинэ гишүүн томилогдсон.

3.8.4. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвших болсон;

3.9. Зөвлөлийн гишүүнийг дараах үндэслэлээр Комиссын хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Комиссын даргын тушаалаар Зөвлөлөөс хасна. Үүнд:

3.9.1. Зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр жилдээ 3-аас дээш удаа ирээгүй;

3.9.2. Зөвлөлийн төлөвлөгөөнд туссан ажлыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа биелүүлээгүй;

3.9.3. Комиссын нэрийг өөрийн төлөөлж буй байгууллагын болон хувийн зорилгоор ашигласан;

3.9.4. Олон нийтийн арга хэмжээнд Комиссын байр суурийг илэрхийлж мэдэгдэл хийсэн.

3.10. Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшихээр болсон бол тухайн ээлжил сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө, ээлжит бус сонгуульд нэр дэвших бол тухайн сонгууль болохоос 60 хоногийн өмнө, нөхөн, дахин сонгуульд нэр дэвших бол тухайн сонгууль болохоос 30 хоногийн өмнө тус тус зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ Комиссын даргад гаргана.

### **Дөрөв. Зөвлөлийн гишүүний эрх, үүрэг, хориглох зүйл**

4.1. Зөвлөлийн гишүүн дараах эрх эдэлнэ. Үүнд:

4.1.1. Комиссоос боловсруулсан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжихтэй холбогдсон бодлогын баримт бичгүүд, үйл ажиллагааны хөтөлбөр, тайлан, төлөвлөгөөний төсөлд санал өгөх;

4.1.2. Комиссын явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг тухай бүр авах;

4.1.3. Комисс болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааны чиглэл, үйл ажиллагааны талаар санал гаргах;

4.1.4. Комиссоос зохион байгуулж буй нөлөөлөл, сурталчилгаа, судалгааны болон бусад бодлогын шинжтэй ажилд Комиссын хуралдаанаас зөвшөөрсөн хүрээнд оролцох.

4.2. Зөвлөлийн гишүүн дараах үүрэг хүлээнэ: Үүнд:

4.2.1. Үйл ажиллагааныхаа үр дүнгийн талаар жил тутам Комиссоос зохион байгуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын уулзалтад тайлагнах;

4.2.2. Хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон зайлшгүй судалж, арга хэмжээ авбал зохих асуудлын талаар Комисст тогтмол мэдээлэл хүргүүлэх;

4.2.3. Хүний эрхийн анхаарал татсан асуудал болон өөрийн салбар дахь хүний эрхийн шинэлэг мэдээллээр Комиссыг хангах;

4.2.4. Төлөөлж буй мэргэшсэн салбарын хүрээнд Комиссын бодлого, үйл ажиллагааны талаар мэдээллээр хангах, тэдгээр байгууллагуудын нийтлэг зорилгыг тууштай илэрхийлэх.

4.3. Зөвлөлийн гишүүнд хориглох зүйл:

4.3.1. Хувийн болон байгууллагынхаа үйл ажиллагаанд Комиссын нэр, таних тэмдэг бүхий Зөвлөлийн гишүүний үнэмлэхийг ашиглах;

4.3.2. Комиссын үйл ажиллагааны талаар батлагдаагүй, тодорхой бус мэдээллийг олон нийтэд түгээх;

4.3.3. Зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр Зөвлөлийн байр суурийг олон нийтэд мэдээлэх;

4.3.4. Зөвлөлийн үйл ажиллагаа, шийдвэрийг аливаа сонгууль болон бусад зорилгоор улс төрийн хэлбэрээр ашиглах.

### **Тав. Зөвлөлийн ажлын зохион байгуулалт, ажиллах журам**

5.1. Зөвлөлийн дарга Зөвлөлийн үйл ажиллагааг удирдана.

5.2. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, гишүүдийг мэдээллээр хангана.

5.3. Зөвлөл жилд 4-өөс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн хурлаас гишүүдийн саналыг үндэслэн тодорхой асуудлаар шийдвэр гарна. Зөвлөлийн хурлын шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно.

5.4. Зөвлөлийн шийдвэрийг Комиссын хэвлэмэл хуудас дээр хэвлэж, Зөвлөлийн дарга бөгөөд Комиссын гишүүн гарын үсэг зурж баталгаажуулна.

5.5. Зөвлөлийн шийдвэрийг Комиссын хуралдаанд танилцуулж, шаардлагатай тохиолдолд зохих шийдвэр гаргуулахаар уламжилна.

5.6. Зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудлын чиглэлийг хуралдаанаас 5-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.

5.7. Шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн ээлжит бус хурлыг Зөвлөлийн гишүүдийн олонхын санаачилгаар Зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.

5.8. Зөвлөл нь Комиссын стратеги төлөвлөгөө, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан улирал тутам Комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

### **Зургаа. Хурлын дэг**

6.1. Зөвлөлийн хурлыг Зөвлөлийн дарга даргалж, хуралдуулна.

6.2. Зөвлөлийн гишүүд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд хуралд заавал оролцоно.

6.3. Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй тохиолдолд хурал зарлагдсан өдрөөс 2 хоногийн өмнө мэдэгдэх бөгөөд хурлын дараа саналаа цахим хэлбэрээр 3 хоногт багтааж ирүүлж болно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд оролцож

амжаагүй гишүүнд хурлын баримт бичиг, шийдвэрийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга тухай бүр хүргүүлнэ.

6.4. Гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь гадаад, дотоодод томилолтоор ажиллаж буй, онцгой болон гамшгийн нөхцөл үүссэн, хорио цээрийн дэглэм тогтоосон тохиолдолд хурлыг цахимаар зохион байгуулж нийт гишүүдийн оролцоог хангана.

6.5. Хуралд Комиссын Тамгын газрын дарга заавал оролцох бөгөөд хэлэлцэх асуудлын онцлогийг харгалзан Комиссын дарга, гишүүд, ажилтнууд саналаараа оролцож болно.

6.6. Хуралд хэлэлцэх асуудлаас хамаарч иргэд, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн болон олон улсын байгууллагын төлөөлөл ажиглагчаар оролцож болно.

6.7. Зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

6.7.1. Зөвлөлийн ажлын төлөвлөгөөний төсөл;

6.7.2. Зөвлөлийн ажлын төлөвлөгөөний биелэлт;

6.7.3. хүний эрхийн тулгамдаж байгаа болон цаг үеийн асуудал;

6.7.4. Хүний эрхийн Үндэсний Комисс болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааны нэгдсэн бодлого;

6.7.5. хамтран зохион байгуулах арга хэмжээ;

6.7.6. Хүний эрх хамгаалагчийн хорооны гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн гишүүнийг сонгох;

6.7.7. Комиссын стратеги төлөвлөгөө болон бодлогын бусад баримт бичгийн төсөл;

6.7.8. бусад асуудал.

6.8. Хуралдаан бүрд өмнөх хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн талаар Зөвлөлийн нарийн бичгийн дарга бэлтгэн танилцуулна. Өмнөх хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн талаар гишүүн тус бүр саналаа гаргаж хуралдаанаар тогтоосон хугацаанд багтаан хэлэлцүүлнэ.

6.9. Хуралд дараах журмыг баримтална:

6.9.1. Хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн асуудлыг дарааллын дагуу нэг бүрчлэн хэлэлцэнэ.

6.9.2. Хурал удирдагчийн зөвшөөрснөөр гишүүд санал гаргах бөгөөд санал гаргах, үг хэлэх хугацааг тухайн үед нь тогтооно. Асуулт, хариулт, санал нь хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой товч, тодорхой байна.

6.9.3. Зөвлөлийн гишүүд санал зөрүүтэй асуудлаар санал хураалт зохион байгуулж болно.

6.9.4. Хурал даргалагч хэлэлцэж байгаа асуудлын талаар гаргасан саналыг нэгтгэн дүгнэж, Зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана.

### **Долоо. Хурлын явцыг баримтжуулах, архивлах журам**

7.1. Хурлын тэмдэглэлийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу хөтөлж, Зөвлөлийн даргад танилцуулж баталгаажуулна.

7.2. Хурлын шийдвэр, бусад холбогдох материалыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдаанаас хойш ажлын 5 өдөрт багтаан албажуулна.

7.3 Хурлын товч болон дэлгэрэнгүй тэмдэглэл, холбогдох материалуудыг нэгтгэн жил бүрийн эцэст архивын нэгж болгон архивд шилжүүлнэ.

7.4. Зөвлөлийн хуралдаан, үйл ажиллагааны талаарх мэдээллийг Комиссын цахим хуудас болон улирал бүрийн Комиссын мэдээллийн хуудсаар дамжуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд түгээнэ.

### **Найм. Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт**

8.1. Зөвлөлийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг Комиссын жилийн төсөвт тусгана.

8.2. Зөвлөлийн гишүүдэд үүрэгт ажилд оролцсон байдлаар урамшуулал олгож болно.

### **Ес. Иргэний нийгмийн зөвлөлийн тайлан**

9.1. Зөвлөлөөс жил бүр үйл ажиллагааны тайлан гаргаж 12 дугаар сарын 25-ны дотор багтаан Комиссын Тамгын газраар дамжуулан Комиссын хуралдаанд танилцуулах бөгөөд Зөвлөлийн тайланг олон нийтэд мэдээлнэ.

9.2. Энэ дүрмийн 9.1-т заасан тайланд Зөвлөлийн гишүүн тус бүрийн тайланг хавсаргах бөгөөд Зөвлөлийн гишүүн тийнхүү тайлан гаргаж өгөх үүргээ удаа дараа биелүүлээгүй буюу 1 сараас дээш хугацаагаар хожимдуулсан нь энэ дүрмийн 3.9-д заасны дагуу Зөвлөлөөс хасах эсэх асуудлыг хэлэлцэх үндэслэл болно.

### **Арав. Бусад зүйл**

10.1. Дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Комиссын хуралдаанаар хэлэлцэн Комиссын даргын тушаалаар баталгаажуулна.